



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16  
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2020. 12. 18 № 7/5585  
танай -ны № -т

Г АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ГАЗАР, ТӨРӨЛЖСӨН  
МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН ДАРГА,  
ЗАХИРАЛ НАРТ

Г Албан бичиг хүргүүлэх тухай

Улс оронд үүсээд байгаа нөхцөл байдалд үндэслэн коронавируст халдварын тархалтыг хязгаарлах, халдварын сэргийлэлт, хяналтыг сайжруулах, эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг хангах, иргэдэд үзүүлэх үндсэн тусламж, үйлчилгээний тасралдуулахгүй байхад чиглэн эмнэлэг бүр онцгой анхаарал хандуулж, зохион байгуулалттай, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Иймд коронавируст халдварын илрүүлэг, сэрэмжлүүлгийг идэвхжүүлж, дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана уу.

1. Эрүүл мэндийн байгууллагын удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

- 1.1. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах төлөвлөгөөндөө коронавируст халдварын үеийн бэлэн байдал, халдварын сэргийлэлтийн чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа халдварын нөхцөл байдалд уялдуулан тодотгол хийх, нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;
- 1.2. Байгууллагынхаа тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, хүний нөөцийн судалгааг гаргах, нэгдсэн бүртгэлийн burtgel.mohs.mn-д шивэх, дайчлагдан ажиллах эмчийн нөөцийн төлөвлөлтийг байнга тодотгох, эмнэлгийн эмч, мэргэжилтний эрүүл мэндийг нь дэмжих арга хэмжээг авах;
- 1.3. Халдварын дэгдэлтийн нөхцөл байдалд үндэслэн эмнэлгийн тусламжийн бэлэн байдал, тохиолдлын удирдлагын тогтолцооны багийг чадавхжуулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах;
- 1.4. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын ажилтан, дэмжих үйлчилгээний ажилтнуудад зориулсан сургалтыг (халдварын сэргийлэлт, хяналт, эрсдэл, аюулгүй байдал, сэтгэл зүйн) тасралтгүй зохион байгуулах, коронавируст халдварын оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулахад чиглэсэн сургалтуудад эмнэлгийн мэргэжилтнүүдийг бүрэн хамруулах;
- 1.5. Эмнэлэг бүхэлдээ халдварт өртөхөөс сэргийлэх арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэлтийн нөөц төлөвлөлтийг гарган хяналт, сургуулиалт хийх;
- 1.6. Коронавируст халдварын эрсдэл үүссэн үед тусламж, үйлчилгээг шилжүүлэн тасралтгүй байдлыг хангахад чиглэн ижил тусламж,

14420956:

- үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмж, хүний нөөц, чадавхийн судалгааг гаргаж, тусlamж, үйлчилгээний ачаалал хуваалцахад урьдчилан зөвшилцөлд хүрсэн байх
- 1.7. Эмнэлэгт үүссэн нөхцөл байдлын талаар холбогдох журмын дагуу шуурхай мэдээлэл өгч хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах;
  - 1.8. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг чадавхжуулах, тусlamж, үйлчилгээний төвлөрлийг үүсгэхгүй байхад чиглэн цахимаар оношилгоо, эмчилгээний зөвлөгөө өгөх, шуурхай байдлыг хангах зорилгоор мэдээллийн урсгалыг тодорхой болгож түгээх,

2. Халдвартын сэргийлэлт, хяналтын чиглэлээр:

- 2.1. Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээний төлөвлөгөөг гарган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
- 2.2. Шаардлагагүй тохиолдолд бага насын хүүхдийг дагуулж эмнэлгээр зорчих иргэдийн хөдөлгөөнийг багасгах;
- 2.3. Хэвтэн эмчлүүлэгчийн эргэлтийн урсгалыг бүрэн зогсоох;
- 2.4. Коронавируст халдвартын үед улсын хэмжээнд үзүүлдэг тусlamж, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэн халдвартын сэргийлэлтийн хяналтыг өндөржүүлэх;
- 2.5. Эрсдэлт бүлгийн хүн амд үзүүлэх /5 хүртэлх насын хүүхэд, 65 нааснаас дээш өндөр настан, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, сүрьеэ, гемодиализ, хавдар, архаг өвчтэй иргэд, дархлаа дарангуйлах эм хэрэглэдэг/ эмнэлгийн тусlamж, үйлчилгээг тасалдуулахгүй байхад мэс засал, дурангийн болон амьсгалын замын халдвартын тусlamж, үйлчилгээг тасалдуулахгүй байдах онцгой анхаарч, тасаг, нэгжийн халдвартын сэргийлэлтийг улам сайжруулах;
- 2.6. Ахуйн болон аюултай хог хаягдлын цуглуулалт, түр хадгалалт, тээвэрлэлт устгалын байдалд хяналт тавих;
- 2.7. Үйлчилгээний танхим, үзлэгийн кабинет, хэвтэн эмчлүүлэх тасаг, байгууллагадаа байгаа бусад аж, ахуй нэгж, байгууллагуудын цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлтэд хяналт тавих;
- 2.8. Амбулаториор үйлчлүүлэгчдэд тархвар зүйн асуумж болон эмнэлзүйн шинж тэмдгийн тандалт хийж, сэжигтэй тохиолдлыг тусгаарлах, КОВИД-19 халдвартын түргэвчилсэн оношилгоонд хамруулах, эргэлзээтэй болон эерэг хариуг гарсан тохиолдолд PCR шинжилгээнд хамруулах, тусгаарлалтын хугацаанд иргэний амин үзүүлэлтийг хянаж, шаардлагатай эмчилгээг халдвартын сэргийлэлтийн дүрэм журмыг чанд мөрдөн хийх;
- 2.9. Хүлээн авах, яаралтай тусlamжийн хэсгийг 2 урсгалтай болгох, амьсгалын замын халдвартын шинж тэмдэгтэй иргэдийг шинж тэмдэггүй иргэдээс тусдаа урсгалаар хүлээн авах, халдварт хамгааллын дэглэмийн дор тусlamж, үйлчилгээг үзүүлэх,
- 2.10. Хэвтэн эмчлүүлэх иргэд болон PCR шинжилгээгээр коронавируст халдвартын илрүүлгийг хийх,

- 2.11. Мэс заслын тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэн бурд коронавируст халдварын түргэвчилсэн оношилгоог хийж, эргэлзээтэй тохиолдолд PCR шинжилгээнд хамруулна. Амь насны заалтаар яаралтай мэс заслын тусламж, үйлчилгээг холбогдох зөвлөмжийг дагуу халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж мэс заслын тусламж, үйлчилгээнд хамруулах;
3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах чиглэлээр:
  - 3.1. Эмнэлэгт суурилсан тандалтыг эрчимжүүлэх амьсгалын цочмог хүнд халдвартай өвчтэй иргэд болон эрчимт эмчилгээний тасагт амьсгалын замын халдварын шалтгаанаар эмчлүүлж байгаа иргэн бүрийг коронавируст халдварын түргэвчилсэн болон PCR шинжилгээнд хамруулах, томуугийн тандалтын тогтолцооны мэдээллийг журмын дагуу тогтмол мэдээлэл өгөх;
  - 3.2. Лабораторийн бэлэн байдал, урвалж, оношлуурын нөөцийг бүрдүүлэх,
  - 3.3. Тусгаарлан ажиглах байр, өрөө, тасгийн бэлэн байдал, сэжигтэй тохиолдлыг шилжүүлэн байршуулах бэлтгэл сургуулилтыг хийж, замын зураглалыг тодорхойлох зэрэг, явцын түргэвчилсэн хяналт хийж, эмнэлгийн мэргэжилтнүүдийг дадлагажуулах;
  - 3.4. Эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдалд усан хангамж, цахилгаан, дулаан, сантехникийн хэвийн ажиллагааг хангах, сэлбэг хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх
  - 3.5. Байгууллагынхаа эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчдын эрүүл мэндийг нь дэмжих арга хэмжээг тогтмол авч, үйлчлүүлэгчээс тусдаа хаалгаар орж гарах урсгалын зохион байгуулалтыг хийж, тасаг, нэгжүүдийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, шаардлагагүй тохиолдолд байршилаа сольж өөр тасаг нэгж кабинетаар явуулахгүй байх,
  - 3.6. Тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцөд байнга хяналт тавьж, эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн холбогдох арга хэмжээг авах
  - 3.7. Архаг хууч өвчтэй болон эмчилгээний хяналттай иргэдийг эмнэлэгт олон ирүүлэхгүй байх зорилгоор хяналтын эмчийн зөвлөгөө мэдээллийг утсаар авах боломжийг бүрдүүлэх, шаардлагатай тохиолдолд гэрээр тусламж, үйлчилгээ үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх зохицуулалтыг хийх,
  - 3.8. Амбулаторийн хүлээлгийн хэсэгт үйлчлүүлэгчдэд зориулсан коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх анхааруулга, зөвлөмжийг байршуулах
  - 3.9. Эрүүл мэндийн байгууллагаараа үйлчлүүлэгчдийг QR код уншуулах, амбулаторийн үзлэгийн кабинет, оношилгооны болон хэвтэн эмчлүүлэх тасаг, тасаг, эргэлтийн хэсэгт QR кодыг байршуулж, уншуулах зөвлөмжөөр хангах,
4. Хот хоорондын зорчих хөдөлгөөнд хяналт хийгдэж байгаатай холбоотой дараах асуудлыг анхаарах

- 4.1. Орон нутгаас эмнэлэг хооронд шилжүүлэх өвчтөний талаар харилцан мэдээлэлтэй байж, тусlamж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад онцгой анхаарч шилжүүлэх
- 4.2. Хот хооронд зорчих хугацаанд эмнэлгийн тусlamж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг хяналтын товчоонд ажиллаж байгаа эмч эрэмбэлэн ангилж, эмнэлгийн тусlamж, үйлчилгээ яаралтай шаардлагатай тохиолдолд түргэн тусlamж, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт хүргэж өгнө, 103-аар тээвэрлэгдэж ирсэн коронавируст халдвaryн голомттой бүс нутгаас ирсэн иргэдийг тусгаарлан, шаардлагатай шинжилгээнд хамруулан, халдвар хамгааллын дэглэмийг дор эмчилгээ үйлчилгээнд хамруулна.

Хавсралтаар “Коронавируст халдвaryн тусlamж, үйлчилгээ үзүүлэхэд эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх, хянах зөвлөмж”-ийг хүргүүлж байна.

Хавсралт 2 хуудастай.



## **ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫГ ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ ЗӨВЛӨМЖК**

1. Өвчтөний өрөөнд орж тусламж, үйлчилгээ үзүүлсний дараа өвчтөнтэй харьцсан хамгаалах хувцас хэрэгслээ тайлаад, цэвэр хувцас сольж өмссөний дараа өвчний түүх, сувилгааны карт зэрэг баримт бичгүүдтэй харьцах;
2. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтныг батлагдсан тохиолдолтой ажиллахаас өмнө гар угаах халдвартгүйжүүлэх, хамгаалах хувцас өмсөх тайлах дадлыг эзэмшүүлж, хүн тус бүрээр нэг бүрчлэн шалгаж оруулах;
3. Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан заавар, журам, зөвлөмжийг хүн бүрт уншуулж, танилцуулах, мөрдөж ажиллахыг анхааруулах;
4. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтныг батлагдсан тохиолдолтой ажиллахаас өмнө хамар, залгиураас вирус илрүүлэх PCR шинжилгээнд хамруулах, цаашид З хоногийн давтамжтай шинжилгээг авах, шаардлагатай тохиолдолд цээжний рентген шинжилгээ хийх, хэрэв эргэлзээтэй бол компьютер томографийн шинжилгээ хийх;
5. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны хоол хүнс нь улаан, шар бүсээр дамжин орж байгаа урсгалыг засах, хоол хүнсний гаднах битүүмжлэлийг сайжруулах;
6. Тусгаарлагдан ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанд шинж тэмдгийн тандалтыг өдөр бүр хийж, халууныг өдөрт 2 удаа хэмжих;
7. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтныг ногоон бүсэд хоорондоо нь харьцуулахгүйгээр тусад нь өрөөнд байлгах, зайлшгүй шаардлагаар хоорондоо харьцах үед нэг удаагийн амны хаалт зүүлгэж хэвшүүлэх;
8. Нэг өрөөнд хоол, цайгаа хамт ууж идэхийг хориглох;
9. Шар бүсийг камержуулж, хувцас тайлах үед алдаа гаргаж байгаа эсэхийг тогтмол хянаж, алдаа дутагдлыг тухай бүрт нь засч, халдварт өртөх эрсдэл гаргасан ажилтны ажлыг зогсоож, тусгаарлан ажиглалтад 14 хоног авах;
10. Баг ахлан ажиллаж байгаа албан тушаалтанд халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг давхар хариуцуулах;
11. Эмнэлзүйн шинж тэмдэг илэрвэл ахлан ажиллаж байгаа албан тушаалтан болон тархвар судлаачид яаралтай мэдэгдэх;
12. Хувцас өмсөх, тайлах, гарын эрүүл ахуй сахилт, цэвэрлэгээ халдвартгүйжүүлэлтийг өдөр бүр шалгах хуудсаар хянах, түүнд тархвар судлаач хяналт тавих;
13. Хамгаалах хувцас өмсөхдөө амны хаалтыг 2 давхарлаж зүүхгүй байх, ялангуяа шүүлтүүртэй амны хаалтны дотор нэг удаагийн амны хаалт зүүх нь нүүрэнд N95 амны хаалт бүрэн наалдаж бүтүүмжлэл үүсэхгүй болдог гэдгийг ойлгуулах;
14. Нэг удаагийн үзлэгийн бээлийг ажил дууссаны дараа шууд тайлах, халдвартгүйжүүлэхгүй байх;

- 15.Өвчний түүх, судалгааны карт зэрэг цаасан материалтай харьцахдаа нэг удаагийн амны хаалт зүүж, бээлий өмсөж, ажил дууссаны дараа гараа угааж, халдвартайжүүлэх;
- 16.Өвчтөний болон ажилтнуудын өрөөний агааржуулалтыг сайтар хийж, агааржуулалтын системгүй бол салхивчаар агаар сэлгэлтийг 2 цаг тутамд хийх;
- 17.Ногоон, шар бүсийн цэвэрлэгээ халдвартайжүүлэлтэд онцгой анхаарч, цэвэрлэгээний материалыг бүс тус бүрт тусад нь байлгах;
- 18.Улаан бүсэд орж ажилласан ажилтны бүртгэлийг хийж, ажилласан өдөр, цаг хугацаа, ямар зорилгоор орсоныг тасаг бүр тэмдэглэх;
- 19.Улаан бүсэд дата ашиглах, цаасан материалын зураг авах, гадагшаа харьцах утас байрлуулах, эмч эмнэлгийн мэргэжилтэн улаан бүсэд гар утас авч орохгүй байх;
- 20.Хамгаалах хувцас хэрэгсэл хийх 50 литрээс дээш хэмжээтэй халдвартай хог хаягдлын “БИОАЮУЛТАЙ” таних тэмдэг бүхий уут, гар хүрэлцэхгүй нээж хаагдах савыг байршуулах;
- 21.Халдвараас сэргийлэх чиглэлээр тусгайлсан зөвлөмж шаардлагатай бол ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны албаны тасгийн эрхлэгч Ж.Нямсүрэн (утас 88084595), тархвар судлаач М.Цолмон (утас 99702944) нартай холбогдон ажиллана уу.

ооОоо